



ДОТООД АУДИТОРЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын сэдэв: 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ
ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН САЙТ, МЭДЭЭЛЛИЙН ШИЛЭН САМБАРТ
БҮРЭН ОРУУЛСАН ЭСЭХ, ШИЛЭН ДАНСНЫ АУДИТЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД АУДИТ ХИЙХ.

АУДИТ ХИЙГДСЭН НЭГЖ: ЗУХ, СБЭЗХ, ХААХ, ИА

АУДИТЫН ТӨРӨЛ: ТӨЛӨВЛӨГӨӨТ ШАЛГАЛТ

АУДИТЫН ХУГАЦАА: 2025.07.08-2025.08.15

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
 - 2.1 Аудитын зорилго
 - 2.2 Аудитын цар хүрээ
3. АУДИТЫН ҮР ДҮН
 - 3.1 Илэрсэн асуудлууд
4. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны даргын баталсан “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК (“ЭДЦС” ТӨХК)-ийн “2025 оны эхний хагас жилийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж үнэлэлт өгөх” удирдамжийн хүрээнд дотоод аудит хийж гүйцэтгэв.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Компанийн шилэн дансны аудитын тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, илэрсэн асуудлыг арилгуулах.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт (ИА, ЗУХ, СБЭЗХ, ХААХ)

- Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээлэл хуулийн хугацаанд байршсан эсэх.
- Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга бодитой байгаа эсэх.
- Ил тод мэдээллийн самбарт мэдээллийг бүрэн байршуулсан эсэх.

2.2 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитыг Эрчим хүчний сайдын 12 дугаар сарын 01-ний өдрийн А/271 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний салбарт мөрдөх дотоод аудитын аргачлал”-ын хүрээнд, холбогдох бичиг баримтад дүгнэлт хийлээ. Дотоод аудитын хэрэгжүүлэхэд дараах эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Шилэн дансны тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Гүйцэтгэх захиралын 2024 оны 10 дугаар сарын А/137 дугаар тушаал;

Шилэн дансанд мэдээлсэн мэдээллийг холбогдох нотлох баримттай тулган шалгахад дараах байдалтай байна. Тайлант хугацааны байдлаар 7 хоногийн дотор буюу тухай бүр мэдээлэх мэдээллийг мэдээлсэн байдал. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ: Нийт 236 зарлагын гүйлгээ байршуулахаас 236 гүйлгээг байршуулсан байна. Нийт цаг хугацаандаа мэдээлж буй байдал 100%-тай хэрэгжсэн байна.
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ: Нийт 596 орлогын гүйлгээ байршуулахаас 596 гүйлгээг байршуулсан байна. Нийт цаг хугацаандаа мэдээлж буй байдал 100%-тай хэрэгжсэн байна.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл: Нийт үнэлгээний хорооны байгуулах тухай 77 тушаал, түүнтэй холбоотой гишүүдийн ашиг сонирхолын мэдүүлгийг байршуулахаас 73 мэдээг байршуулсан ба

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

нийт 1093,486,500.0 төгрөгийн 7 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна. “А” 17,94,101,120 дугаартай нийт 180,000,000.0 төгрөгийн 4 тушаалыг мэдээллээгүй байна. Нийт цаг хугацаандаа мэдээлж буй байдал 86%-тай, мэдээлсэн байдал 95%-тай, хэрэгжсэн байна.

№	Тендерийн үнэлгээний хороо байгуулсан тушаал	Үнийн дүн	Тушаалын огноо
1	A/17 "Дотоод хяналтын системийг компьютерын хяналт удирдлагад шилжүүлэх"	39,400,000.0	2025.02.12
2	A/94 "Toyota prius 55 маркийн автомашин-1 ширхэг"	50,000,000.0	2025.04.10
3	A/101 "НОВ ХХБ-д 0.4кВ-ын автоматыг шинэчлэх-2 ширхэг"	40,600,000.0	2025.04.10
4	A/120 "Турбины конденсаторын хөргөлтийн усыг боловсруулах, ус бэлтгэлийн химийн бодисын орцын нормыг тогтоолгох зөвлөх үйлчилгээ авах"	50,000,000.0	2025.06.02
Нийт		180,000,000.00	

- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр: Нийт 83 гэрээ, 32 буцалтгүй тусламж болон тэтгэмж, урамшуулал олгосон тушаал байршуулахаас 52 гэрээ, 24 тушаалыг байршуулсан ба 3 тушаалын хугацааг хоцроож байршуулсан байна. 31 гэрээ, 8 тушаалыг мэдээллээгүй байна. Нийт цаг хугацаандаа мэдээлж буй байдал 37%-тай, мэдээлсэн байдал 66%-тай хэрэгжсэн байна.

- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл: Нийт 73 тендерийн 114 үр дүнг байршуулахаас 95 үр дүнгийн мэдээг байршуулсан ба 8 тендерийн 9 үр дүнг хугацаа хороож мэдээлсэн байна. 17 тендерийн 19 үр дүнг мэдээллээгүй байна. Нийт цаг хугацаандаа мэдээлж буй байдал 75%-тай, мэдээлсэн байдал 83%-тай хэрэгжсэн байна.

Дээрх мэдээг хүснэгтээр харуулбал

№	Тайлангийн төрөл	Хариуцсан нэгж	Мэдээлбэл зохих мэдээний тоо	Мэдээлсэн мэдээний тоо	Зөрүү	Гүйцэтгэл хувь	Хугаа хоцроож мэдээлсэн тоо
1	"Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ"	СБЭЗХ	596	596	0	100%	0
2	"Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ"	СБЭЗХ	236	236	0	100%	0
3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	ХААХ	77	73	-4	95%	7
4	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	ХААХ	115	76	-39	66%	3

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

5	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	ХААХ	114	95	-19	83%	9
Нийт			1024	981	-43		

Шилэн дансны цахим хуудсанд сар болон жилд нэг удаа байршуулдаг дараах мэдээг хуульд заасан хугацаанд мэдээлсэн байна. Үүнд:

- Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл;
- Тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлт;
- Худалдан авах ажиллагааны тайлан;
- Байгууллагын батлагдсан төсөв
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргын 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдөр баталсан 2025.07.08-2025.07.31-ний өдөр хүртэлх хугацаанд аудит хийхээр удирдамж батлагдсан. 2025.07.03-ны өдөр удирдамж, аудит хийхэд шаардлагатай материалын жагсаалтыг компанид хүргүүлсэн.

№	Баримт бичгийн нэр	Материал ирүүлэх огноо	Материал ирүүлсэн огноо	Холбогдох нэгж	Тайлбар
1	2025 оны эхний хагас жилийн мөнгөн гүйлгээний орлого, зарлагын баримтын жагсаалтыг программаас, өссөн дүнгээр;	2025.07.08	2025.07.09	СБЭЗХ	
2	2025 оны эхний хагас жилийн гэрээний бүртгэл, гэрээ (гэрээний дүн)	2025.07.08	2025.07.21-25	ХААХ	3-7 хоног хугацаа хоцроосон
3	Гүйцэтгэх захирлын 2025 оны эхний хагас жилийн тушаалууд;	2025.07.08	2025.07.25	ЗУХ	7 хоног хугацаа хоцроосон
4	Компанийн 2025 оны эхний хагас жилд батлагдсан зорилтод түвшин, түүний гүйцэтгэл	2025.07.08	2025.08.15	СБЭЗХ	22 хоног хугацаа хоцроосон
5	2025 оны эхний хагас жилийн байдлаар ИЗ, ТЗБАХ, ХО-ын төлөвлөгөө, түүний биелэлт	2025.07.08	2025.07.21	ИА	
6	2025 оны эхний хагас жилд батлагдсан компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;	2025.07.08	2025.08.19	ХААХ	25 хоног хугацаа хоцроосон
7	2025 оны эхний хагас жилд байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, шийдвэрүүд	2025.07.08	2025.08.15	СБЭЗХ	22 хоног хугацаа хоцроосон
8	Аудитын хугацаанд компанийн зорилтод түвшингийн үзүүлэлтийг сар сараар баталсан төлөвлөгөө	2025.07.24		СБЭЗХ	Ирүүлээгүй

Ирүүлсэн материалын хүрээнд аудитыг хийж 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр илэрсэн асуудлын бүртгэлд тайлбар авахаар компанид хүргүүлсэн.

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

№	Холбогдох нэгж	Тайлбар ирүүлэх огноо	Тайлбар
1	СБЭЗХ	2025.08.26	Ирүүлээгүй
2	ХААХ		Ирүүлээгүй
3	ЗУХ		Ирүүлсэн
4	ИА		Ирүүлсэн

3. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1

Шилэн дансанд байршуулах 4 төрлийн 20 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

Бодит байдал:

➤ “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн мэдээллийн талбарт: Нийт 92,772,544.0 төгрөгийн 3 тушаалын хугацаа хоцроож байршуулсан байна.

№	Тушаалын огноо	Тушаалын дугаар	Тушаалын агуулга	Үүсгэсэн огноо	Үнийн дүн	Үүсгэвэл зохих огноо (дотор)
1	1/9/2025	Б/26	Цалинтай чөлөө, буцалтгүй тусламж олгох тухай	1/16/2025	2,000,000.0	1/6/2025
2	2/19/2025	Б/147	Цалинтай чөлөө, буцалтгүй тусламж олгох тухай	2/25/2025	2,000,000.0	2/17/2025
3	4/16/2025	Б/267	Тэтгэмж олгох тухай	4/22/2025	86,772,544.0	4/14/2025
Нийт дүн					90,772,544.0	

➤ “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл” гэсэн мэдээллийн талбарт: Нийт 1093,486,500.0 төгрөгийн 7 тушаал болон түүнтэй холбоотой үнэлгээний хорооны гишүүдийн ашиг сонирхолын мэдүүлгийг хуудсыг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

№	Тендерийн үнэлгээний хороо байгуулсан тушаал	Үнийн дүн	Тушаалын огноо	Шилэн дасанд үүсгэсэн огноо	Шилэн дасанд үүсгэвэл зохих огноо
1	A/34 "Зуух №2-ын компьютерийн хяналт удирдлагын системийн материал-1 ком."	101,000,000.0	2025.02.21	2025.03.07	2025.02.28
2	A/35 "Бутлагчийн цахилгаан хөдөлгүүр, роторын мушгилтын момент-88, механизмын гол дээрх-Мхяз-2000"	120,000,000.0	2025.02.21	2025.03.07	2025.02.28
3	A/58 "Тээрмийн ган бөмбөлөг нийлүүлэх"	300,000,000.0	2025.03.07	2025.03.24	2025.03.14
4	A/59 "Хөдөлмөр хамгаалах хэрэгсэл"	164,976,500.0	2025.03.07	2025.03.24	2025.03.14
5	A/60 "Илчит тэрэгний сэлбэг нийлүүлэх"	20,000,000.0	2025.03.07	2025.03.24	2025.03.14
6	A/74 "Ковш-1 ширхэг"	350,000,000.0	2025.03.21	2025.03.31	2025.03.28
7	A/77 "Цахилгаан үүсгүүр"	37,510,000.0	2025.03.21	2025.04.14	2025.03.28
Нийт дүн		1,093,486,500.0			

➤ Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл: Нийт 8 тендерийн 972,759,800.0 төгрөгийн 9 үр дүнг хугацаа хороож мэдээлсэн байна.

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	2025 оны төсөвт өртөг	Тендерийн үр дүн гарсан огноо
1	Төрөл бүрийн хаалт, вентил нийлүүлэх	207,746,800.0	2025.03.12-ны өдрийн тендерийн үр дүнг 2025.04.18-ны өдөр мэдээлсэн байна.
2	Төрөл бүрийн тос, масло нийлүүлэх	322,773,000.0	2025.03.18-ны өдрийн тендерийн үр дүнг 2025.03.26-ны өдөр мэдээлсэн байна.
3	Вагон хөмрөгчийн бутлагч фрезерийн хөдөлгүүр редукторууд, цахилгааны кабель удирдлагын хэлхээг бүрэн шинэчлэх	109,000,000.0	2025.06.26-ны өдрийн үр дүнг 2025.07.07-ны өдөр хугацаа хоцроож мэдээлсэн
4	АРАХ серийн контроллёрууд	60,640,000.0	2025.03.28-ны өдрийн үр дүнг 2025.04.18-ны өдөр хугацаа хоцроож мэдээлсэн
5	Төрөл бүрийн ажлын дугуй нийлүүлэх	67,100,000.0	2025.05.19-ны өдрийн тендерийн үр дүнг 2025.05.30-ны өдөр мэдээлсэн байна.
6	Төрөл бүрийн тосон сальник нийлүүлэх	24,150,000.0	2025.05.20-ны өдрийн тендерийн үр дүнг 2025.05.30-ны өдөр, 2025.06.06-ны өдрийн тендерийн үр дүнг 2025.06.17-ны өдөр мэдээлсэн байна.
7	Турбины сэлбэг нийлүүлэх	31,350,000.0	2025.05.19-ны өдрийн тендерийн үр дүнг 2025.05.30-ны өдөр мэдээлсэн байна.
8	ТГ №4-д центрфуг шинээр монтажлах	150,000,000.0	2025.05.01-ны өдрийн тендерийн үр дүнг 2025.05.30-ны өдөр мэдээлсэн байна.
Нийт дүн		972,759,800.0	

➤ Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт: ЭХЗХ-ны 2025.02.20-ны өдрийн Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ батлах тухай 34 дүгээр тогтоолыг 2025.02.27-ны өдөрт багтаан мэдээлэх байтал 2025.03.31-ний өдөр хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

➤ Шилэн дансны тухай хуулийн

4.1. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;

6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

6.4.2. тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;

6.4.3. тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан

6.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

➤ МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын

4.1. Төрийн өмчит аж ахуй нэгж дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

4.1.7. хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягын дагуу цахимаар;

4.1.10. зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;

4.1.14. тухайн байгууллага хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар;

4.1.17. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тухай бүр PDF форматаар.

➤ Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/137 дугаар тушаал;

Асуудлын үндсэн шалтгаан:

Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус мөрдлөг болгоогүй байна.

Зөвлөмж:

➤ Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-д заасан хугацааг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах.

Илэрсэн асуудал 2

Шилэн дансанд заагдсан мэдээллийг байршуулаагүй байна.

Бодит байдал:

➤ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл гэсэн мэдээллийн талбарт: Нийт 180,000,000.0 төгрөгийн 4 тушаал, түүнтэй холбоотой үнэлгээний хорооны гишүүдийн ашиг сонирхолын мэдүүлгийг мэдээллээгүй байна.

№	Тендерийн үнэлгээний хороо байгуулсан тушаал	Үнийн дүн	Тушаалын огноо
1	А/17 "Дотоод хяналтын системийг компьютерын хяналт удирдлагад шилжүүлэх"	39,400,000.0	2025.02.12
2	А/94 "Toyota prius 55 маркийн автомашин-1 ширхэг"	50,000,000.0	2025.04.10
3	А/101 "НОВ ХХБ-д 0.4кВ-ын автоматыг шинэчлэх-2 ширхэг"	40,600,000.0	2025.04.10
4	А/120 "Турбины конденсаторын хөргөлтийн усыг боловсруулах, ус бэлтгэлийн химийн бодисын орцын нормыг тогтоолгох зөвлөх үйлчилгээ авах"	50,000,000.0	2025.06.02
Нийт дүн		180,000,000.0	

➤ Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр: Нийт 44,111,500.0 төгрөгийн 6 буцалтгүй тусламж болон тэтгэмж, урамшуулал олгох тухай тушаал, 53,380,000.0 төгрөгийн 3 гэрээг шилэн дансанд мэдээллээгүй байна.

№	Шийдвэрийн				Үнийн дүн
	огноо	дугаар	төрөл	агуулга	
1	2/14/2025	Б/130	Тушаал	Цалинтай чөлөө, буцалтгүй тусламж олгох тухай	2,000,000.0

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

2	2/26/2025	Б/164	Тушаал	Орон сууцны хөрөнгийн дэмжлэг олгох тухай	30,000,000.0
3	2/26/2025	Б/165	Тушаал	Урамшуулал олгох тухай	150,000.0
4	4/21/2025	Б/284	Тушаал	Жирэмсний болон амаржсаны олговор олгох тухай	
5	6/2/2025	Б/393	Тушаал	Тэтгэмж олгох тухай	81,880,793.0
6	6/4/2025	Б/406	Тушаал	Урамшуулал олгох тухай	5,300,000.0
7	6/17/2025	Б/427	Тушаал	Цалинтай чөлөө, буцалтгүй тусламж олгох тухай	2,000,000.0
8	2025.05.28	А/114	Тушаал	Хоолны хөнгөлөлтөд өөрчлөлт оруулах тухай	6,000.0
Тушаалын нийт дүн					121,336,793.0
1	3/17/2025	ЕРР/24Б-56	Гэрээ	Грундфосс насос нийлүүлэх "МЗЭ" ХХК	128,000,000.0
2	2025.06.03	ЭДЦС/007/001	Гэрээ	Компьютер нийлүүлэх "Саммит компьютер технологи" ХХК	37,960,000.0
3	2025.01.01	Г-13/2025	Гэрээ	"Нүүрс нийлүүлэх гэрээ" Шарын гол ХК	41,245,557,700.0
4	2025.03.31	25/13-17	Гэрээ	"Нүүрс нийлүүлэх гэрээ" Багануур ХК	2,311,206,900.0
5			Гэрээ	"Цэвэр ус худалдан авах" Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	5,783,770,400.0
6			Гэрээ	"Ахуйн ус худалдаж авах" Эрдэнэт -Ус ОНӨХК	298,067,500.0
7	2025.01	2025/ДЗ-05	Гэрээ	Диспетчерийн зохицуулалтын гэрээ ДҮТ ТӨХХК	-
8	2025.01	2025/05	Гэрээ	ЦЭХ худалдах, худалдан авах гэрээ ДҮТ ТӨХХК	-
9	2025.01	ЕРР/25Y-01	Гэрээ	Авто тээврийн хэрэгслийн иж бүрэн даатгал Бодь даатгал	11,872,992.0
10	2025.01	ЕРР/25Y-02	Гэрээ	Авто тээврийн хэрэгслийн иж бүрэн даатгал Бодь даатгал	3,102,642.0
11	2025.02.25	ЕРР/25Y-08	Гэрээ	ТӨБЗГ худалдан авах гэрээ	
12	2025.04.14	ЕРР/25Y-09	Гэрээ	Чадамж боломж ХХК Хамтран ажиллах сургалтын гэрээ	8,000,000.0
13	2025.04.14	ЕРР/25Y-10	Гэрээ	Эрхэст оргил ХХК Хамтран ажиллах гэрээ	5,780,000.0
14	2025.05.28	ЕРР/25Y-11	Гэрээ	Дөрвөлжин их бууц ХХК Хамтран ажиллах сургалтын гэрээ	8,000,000.0
15	2024.12.31	ЕРР/25Y-12	Гэрээ	УБТЗ ХНН Хамтран ажиллах гэрээ	
16	2025.01	ЕРР/25Y-13	Гэрээ	Авто тээврийн хэрэгслийн иж бүрэн даатгал Бодь даатгал	2,869,650.0
17	2025.01	ЕРР/25Y-14	Гэрээ	Жолоочийн хариуцлагын албан журам даатгал Бодь даатгал	2,127,708.0
18	2025.01.14	ЕРР/25Y-15	Гэрээ	ШУТИС сэтгүүл захиалах	3,726,000.0
19	2025.04.17	ЕРР/25Y-16	Гэрээ	УБТЗ ХНН Хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийх	5,350,000.0
20	2025.05.06	ЕРР/25Y-17	Гэрээ	Дотоодын цэргийн 821-р тусгай салбар Хамгаалалтын гэрээ	
21	2025.05.20	ЕРР/25Y-18	Гэрээ	Металл центр ХХК шинжилгээ хийх	9,000,000.0
22	2025.04.03	ЕРР/25Y-19	Гэрээ	Жойфүл дэсэндэнтс ХХК Усны шүүлтүүр худалдан авах	
23	2025.02.07	ЕРР/25Y-20	Гэрээ	Голомт банк Цалингийн карт, зээлээр үйлчлэх	
24	2025.02.12	ЕРР/25Y-21	Гэрээ	ЭХҮТөв Ажил үйлчилгээний нэгдсэн үнэлгээ	4,444,273.0
25	2025.01.01	ЕРР/25Y-22	Гэрээ	Орхон хот тохижуулах газар хог хаягдал тээвэрлэх	
26	2025.03.14	ЕРР/25Y-23	Гэрээ	Монгол-Оросын ХНН 6-р анги Салбар зам ашиглалтын гэрээ	17,181,774.0

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

27	2025.01.01	ЕРР/25У-24	Гэрээ	Мэдээлэл холбоо сүлжээ ХХК Антенн, тогө байрны түрээсийн гэрээ	
28	2025.03.01	ЕРР/25У-25	Гэрээ	Юнивишн Хамтран ажиллах гэрээ	
29	2025.06.24	ЕРР/25У-26	Гэрээ	Монгол-Оросын ХНН 6-р анги ТЭМ2 серийн 1285 илчит тэргэнд засвар үйлчилгээ хийх	3,578,000.0
30	2025.08.18	ЕРР/25У-27	Гэрээ	Талын луутан ХХК 0.4кВ-ын асинхрон хөдөлгүүрийн статорын ороомгийн хөндийрүүлэг хэмжих, оношлох аргачлал	3,600,000.0
31	2025.06.30	ЕРР/25У-28	Гэрээ	БСД Эрчим хэмнэлт ХХК Эрчим хүчний аудит	19,800,000.0
Гэрээний нийт дүн					49,912,995,539.0

➤ Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн: Худалдан авах ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлээгүй байна.

➤ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт: Нийт 17 тендерийн 2,222,075,200.0 төгрөгийн 19 үр дүнг шилэн дансанд мэдээллээгүй байна.

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Тендерийн үр дүн гарсан огноо	Мэдээлбэл зохих огноо /багтаан/
1	ТГ №2-ын их засвар хийх	506,900,000.0	2025-04-02	4/9/2025
2	Зуух №2,4 -ийн тоосон системд хэсэгчилэн засвар хийх, циклон сеператорын их бие хэсэгчилэн сольж, дулаалга хийх- /2 ком/	202,500,000.0	2025-05-08	5/15/2025
3	Зуух №3,4-н утааны хийн бров хэсэгчилэн сольж бетонд шилжүүлэх-/2 ком/	165,000,000.0	2025-05-30	6/6/2025
4	Ерөнхий удирдах щитний хэсэгчилсэн их засвар	175,000,000.0	2025-04-28	5/5/2025
5	Ду600мм-ийн ил шугамын дулаалга хэсэгчлэн солих	175,000,000.0	2025-05-07	5/14/2025
6	ТГ №4-д центрфуг шинээр монтажлах 1 ширхэг	150,000,000.0	2025-05-27	6/3/2025
7	Бутлагчийн цахилгаан хөдөлгүүр, роторын мушгилтын момент-88, механизмын гол дээрх 1 ширхэг	120,000,000.0	2025-05-12	5/19/2025
8	МВ цахилгаан хөдөлгүүр, роторын мушгилтын момент-44, механизмын гол 1 ширхэг	110,000,000.0	2025-04-18	4/25/2025
9	Зуух №2-ын компьютерийн хяналт удирдлагын системийн материал 1 ком.	101,000,000.0	2025-05-12	5/19/2025
			2025-06-16	6/23/2025
10	Төрөл бүрийн хаалт,вентил нийлүүлэх	207,746,800.0	2025-03-12	3/19/2025
			2025-05-08	5/15/2025
11	ТДЦ-ийн РЭБ-ийн ашиглалтын душ /70м2/	33,000,000.0	2025-05-22	5/29/2025
12	Гүүрэн кран 1-ийн удирдлагын хэсэг, цахилгааны щит шинэчлэх, цонхны шил сольж, кондишн суурилуулах	33,000,000.0	2025-06-26	7/3/2025
13	Седло өнгөлөгч багаж 1 ширхэг	25,000,000.0	2025-06-26	7/3/2025
14	Аюулгүй нөөцийн материал нийлүүлэх	54,250,000.0	2025-04-01	4/8/2025
15	Төрөл бүрийн кабель нийлүүлэх	65,228,400.0	2025-03-28	4/4/2025
16	Төрөл бүрийн ажлын дугуй нийлүүлэх	67,100,000.0	2025-06-25	7/2/2025
17	Турбины сэлбэг нийлүүлэх	31,350,000.0	2025-06-25	7/2/2025
Нийт		2,222,075,200.0		

Байх ёстой шаардлага /шалгуур/:

- Шилэн дансны тухай хуулийн
 - 4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:
 - 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;
 - 4.1.2.мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;
 - 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;
 - 6.4.2.тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;
 - 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:
 - 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;
 - 6.10.Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.
- МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын
 - 4.1. Төрийн өмчит аж ахуй нэгж дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:
 - 4.1.9. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хийгдсэнээс хойш зарлагын гүйлгээ бүрт түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт 7 хоногийн дотор энэхүү журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;
 - 4.1.10. зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;
 - 4.1.17. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тухай бүр PDF форматаар.
- Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/137 дугаар тушаал;

Асуудлын үндсэн шалтгаан:

- Дээрх зөрчлүүд дахин давтан гарч байгаа нь хариуцсан ажилтны ажлын хариуцлага сул, тэдгээрийн удирдлагын хяналт хангалтгүй байгаатай холбоотой.

Зөвлөмж:

- Байршуулаагүй мэдээ, тайланг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор нөхөж байршуулах.
- Илэрсэн зөрчлүүд удаа дараа гарч байгаа тул дахин давтан гаргахгүй байх, шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд багтаан мэдээллийг тогтмол байршуулж хэвшүүлэхэд зохион байгуулалтын арга хэмжээ авах, түүнд хяналт тавьж ажиллах.

Илэрсэн асуудал 3	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай, хуулийн дагуу нууцад хамруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” зарчим хангагдахгүй байна.
--------------------------	---

Бодит байдал:

- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн: 3 дугаар сард шилэн дансанд мэдээлсэн аудитын тайлан, дүгнэлтийг иж бүрэн мэдээлээгүй байна.
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт: Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг иж бүрэн мэдээлээгүй байна.
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт:
 - ЦЭХ-ний үйлдвэрлэлт, түгээлтийн төлөвлөгөө 5 дугаар сард биелсэн байхад түүний шалтгаан, тайлбар хэсэгт ЦЭХ-ний үйлдвэрлэлт, түгээлт буурсан гэсэн байна.
 - Нийт зардал 2 дугаар сард өссөн байхад түүний шалтгаан, тайлбар хэсэгт зардал хэмнэсэн гэж буруу мэдээлсэн байна.
 - Цалингийн сан 4 дүгээр сард хэтэрсэн байх ба түүний тайлбар, шалтгаан хэсэгт “ээлжийн амралт” гэж оруулсан нь тодорхой бус, 5 дугаар сард цалингийн сангийн хэтэрсэн байхад түүний шалтгааныг тайлбарлаагүй байна.
 - Авлага 1,2 дугаар сард хэтэрсэн байхад түүний шалтгаан, тайлбарт хэсэгт авлага буурсан гэж буруу мэдээлсэн, 6 дугаар сарын авлагын шалтгаан, тайлбар хэсэгт “ДҮТ авлага” гэж оруулсан тодорхой бус тайлбар байна.
 - Ажиллагсдын тооны гүйцэтгэл, түүний шалтгаан тайлбарыг 1,2 дугаар сард үнэн зөв, бодитой мэдээлээгүй, 6 дугаар сард 2 хүний орон тоо дутуу ажилласан гэсэн гүйцэтгэл байхад түүний шалтгаан тайлбарыг “зорилтод түвшингийн хэмжээнд” гэж тайлбарласан зэрэг нь үнэн зөв, бодитой мэдээлээгүй байна.
- “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт” болон “Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт”: Гэсэн 2 мэдээллийн талбарт нийт ажилчдын тоог зөрүүтэй мэдээлсэн байна.

№	Мэдээний нэр	Мэдээлсэн сар	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт	Зөрүү
1	Нийт ажилчдын тоо	1 сар	467	473	6
2		2 сар	469	473	4
3		3 сар	469	470	1
4		4 сар	471	470	-1
5		5 сар	470	471	1
6		6 сар	470	471	1

Байх ёстой шаардлага /шалгуур/:

- Шилэн дансны тухай хуулийн
 - 4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:
 - 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;
 - 4.1.2.мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;
 - 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;
 - 4.1.4.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх.
 - 6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт; 6.3.2.төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт; 6.3.3.төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар; 6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл; 6.4.7.байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт; ➤ МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4.1.2. төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшинг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 17 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар; 4.1.5. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар; 4.1.16. байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн сарын тайланг энэ журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа сарын 8-ны дотор цахимаар; ➤ Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/137 дугаар тушаал;
Асуудлын үндсэн шалтгаан: ➤ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмуудыг мөрдлөг болгож ажиллаагүйтэй холбоотой.
Зөвлөмж: ➤ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч, иргэд олон нийт баталгаажсан үнэн зөв, иж бүрэн мэдээлэлтэй танилцах боломжоор хангах шаардлагатай.

5. Дүгнэлт

Дотоод аудитор нь 2024 онд компанийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2 удаа аудит хийсэн бөгөөд тус аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд: ХААХ-ийн хариуцан байршуулдаг мэдээг цаг хугацаандаа мэдээлээгүй нь сөргөөр нөлөөлж, харин олон тооны мэдээ хариуцан байршуулдаг 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 832 ширхэг гүйлгээг 100 хувь цаг хугацаандаа мэдээлсэн нь эерэг нөлөөллийг бий болгосон байна.

Цөөн мэдээлэл хариуцан байршуулдаг ХААХ-ийн байршуулаагүй мэдээний тоо нь өмнөх 2 аудитаар илэрсэн зөрчлийн тооноос буураагүй, өмнөх дотоод аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа хэвшил болгоогүйгээс илэрсэн зөрчлүүд давтан гарсаар байна. Энэ нь хариуцсан ажилтан болон түүний удирдлагын ажлын хариуцлага сул, өгсөн зөвлөмжид ач холбогдол өгч ажиллаагүйг харуулж байна.

Зөвлөмж:

Хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй дээрх зөрчлүүдийг удаа дараа давтан илэрсэн зөрчлийг бууруулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, холбогдох албан тушаалтад хариуцлага тооцох зөвлөмжийг хүргүүлж байна.

Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр албан бичгээр нотлох, дэмжих баримтын хамт ирүүлнэ үү.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР  Б.ГАНЧИМЭГ

2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр